

БАТЛАВ: СУРГАЛТ, ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ **Н.ЭРДЭНЭХҮҮ**



**ШУТИС-ИЙН ОЮУТНЫ ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
“ЭРДМИЙН ХХИИ ЧУУЛГАН”- НЫ УДИРДАМЖ**

Зорилго:

Их сургуульд суралцагч оюутнуудын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ур чадварыг дээшлүүлэх, бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл, шилдэг бүтээлийг шалгаруулж, нийтийн хүртээл болгох.

Хамрах хүрээ:

Их сургуулийн бакалаврын түвшинд суралцагч оюутнууд (суралцагч гадаад оюутнууд) оролцоно.

Хугацаа:

- I. **Оюутны шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулалт:**
2024 оны 4 дүгээр сарын 05-нд
- II. **Оюутны шилдэг бүтээл шалгаруулалт:** 2024 оны 04 дүгээр сарын 26-нд

I. Оюутны эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага:

1. Асуудлаа тодорхойлсон байдал, хэрэглээ, ач холбогдол
2. Тухайн асуудлыг шийдвэрлэсэн байдал, онцлог шийдэл
3. Техник технологи, эдийн засгийн судалгаа, тооцоолол
4. Оюутны илтгэх ур чадвар
5. Эрдэм шинжилгээний өгүүлэл нь бичлэгийн стандарт шаардлагыг хангасан байдал.

Жич: ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих стандартыг баримтална.

Холбоос: https://www.must.edu.mn/mn/esh_oguulel_zaaavar/

Эрдэм шинжилгээний өгүүлэл шалгаруулах салбар:

- Салбар 1. Техник, технологи
- Салбар 2. Нийгэм, хүмүүнлэг, дизайн
- Салбар 3. Байгалийн ухаан, экологи
- Салбар 4. Эдийн засаг, менежмент

Шалгаруулалт, үе шат

Оюутны шилдэг эрдэм шинжилгээний өгүүллийн шалгаруулалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулна.

1-р шат. Бүрэлдэхүүн сургуулийн оюутны эрдэм шинжилгээний бага хурлаас салбар бүрт эхний 2 байранд шалгарсан оюутнуудын эрдэм шинжилгээний өгүүллийг хэвлэмэл болон файл хэлбэрээр, албан бичгийн хамт 2024 оны 03 дугаар сарын 20- ны дотор чуулган зохион байгуулах комисс хүлээн авна. (файл, ррт-г studentservice@must.edu.mn, хаягт ирүүлнэ) Техник, технологи, Нийгэм, хүмүүнлэг,

дизайн, Байгалийн ухаан, экологийн салбар хуралдааны эхний шатны шалгаруулалтын хэвлэмэл материалыг ШУТИС-ийн хичээлийн I байр 327 тоотод, Эдийн засаг, менежментийн салбар хуралдааны эхний шалгаруулалтын материалыг холбогдох удирдамжийн дагуу 2024 оны 03 сарын 25 ны дотор ШУТИС-ийн БУХС-ийн 204 тоот танхимд хүлээн авна. (файл, ppt-г nyambayar@must.edu.mn хаягаар ирүүлнэ).

2-р шат. Оюутны эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл шалгаруулах нэгдсэн хурал 2024 оны 04 дүгээр сарын 05-нд Техник, технологийн салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 604 тоот танхимд, Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар ШУТИС-ийн номын сангийн 504 тоот танхимд, Байгалийн ухаан, экологийн салбар хуралдаан ШУТИС-ийн номын сангийн 405 тоот танхимд, Эдийн засаг, менежментийн салбар хуралдаан хичээлийн VIII байр 12 давхар “Хурлын танхим”-д тус тус зохион байгуулагдана.

II. Оюутны шилдэг бүтээлд тавигдах шаардлага:

1. Техник, технологийн шийдэл, дэвшилтэт шинэлэг тал
2. Техник технологийн судалгаа, тооцоолол, туршилтын үр дүн
3. Хэрэглээнд нэвтрүүлэх боломж, ач холбогдол
4. Эдийн засгийн үр ашгийн тооцоо (өртөг, зардал, орлого, үр ашиг)
5. Оюутны бүтээлч ажиллагаа (Тухайн бүтээлд багш, оюутны хамтын ажиллагаа, багаар ажилласан байдал, бүтээлийн танилцуулга, бусад)

Жич: Оюутан хамтарсан бүтээлээр оролцож болно.

Шилдэг бүтээл шалгаруулах салбар:

Салбар 1. Техник, технологи

Салбар 2. Дизайн, байгалийн ухаан, экологи

Шалгаруулалт, үе шат:

Оюутны шилдэг бүтээлийн уралдааныг 2024 оны 04 дүгээр сарын 26-нд зохион байгуулна.

Шилдэг бүтээлийн уралдаанд бүрэлдэхүүн сургуулиудаас салбар бүрд шаардлага хангасан шилдэг 3 хүртэлх бүтээлүүдийг оролцуулж болно.

Шилдэг бүтээлийн уралдаанд оролцох оюутны бүртгэлийг албан бичгээр хүлээн авна. Уралдаанд оролцох бүтээл тус бүрийн танилцуулгыг А-3 хэмжээтэй цаасанд өнгөтөөр хэвлэн, ламинатордож 2024 оны 04 дүгээр сарын 20-ны дотор чуулган зохион байгуулах комисст (ШУТИС-ийн хичээлийн I байр 327 тоотод) ирүүлнэ.

Биет бүтээлийг 2024 оны 04 дүгээр сарын 26-ний өдөр шилдэг бүтээлийн шалгаруулалтыг хичээлийн VIII байр 12 давхар “Хурлын танхим”-ийн хуваарилсан талбайд байршуулна. (Өмнөх жилүүдэд оролцсон бүтээлүүд сайжруулсан байдлаа тодорхойлсон тодорхойлолттой байх)

Шагнал урамшуулал:

Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл, шилдэг бүтээлийг салбар тус бүрд 3 хүртэл байр эзлүүлэн шагнан урамшуулна.

I байр Батламж, 800.000 төгрөг

II байр Батламж, 500.000 төгрөг

III байр Батламж, 300.000 төгрөг

Оюутны “Эрдмийн XXIII чуулган”-д оролцож буй оюутны эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг удирдан ажилласан удирдагч багш нараас шилдэг удирдагч багшийг салбар тус бүрд нэг багшийг шалгаруулан батламж, мөнгөн шагналаар шагнан урамшуулна.

“Эрдмийн XXIII чуулган”-д оролцсон оюутнуудын шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийн танилцуулгыг эмхэтгэн хэвлэж хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгоно.

Анхаарах зүйлс:

Эхний шатны шалгаруулалт хийгдээгүй болон хугацаа хоцорсон материал хүлээн авахгүй.

Холбогдох майл хаяг, утас:

Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний
алба хичээлийн I байр 327 тоот өрөө
321184, 324590-1035

[/studentservice@must.edu.mn /](mailto:studentservice@must.edu.mn)

ЧУУЛГАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС